



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

МАТЕРИАЛЫН УРСГАЛЫН ДАНС 2005-2018

Улаанбаатар
2019 он



“МАТЕРИАЛЫН УРСГАЛЫН ДАНС 2005 – 2018”

танилцуулгатай холбоотой мэдээлэл болон санал хүсэлт байвал доорх хаягаар холбогдоно уу.

Хянасан: Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын дарга А.ДЭМБЭРЭЛ

Боловсруулсан: Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын статистикч Ю.БАТЗОРИГТ

Олон нийттэй харилцах хэлтэс:

Онлайн: <http://web.nso.mn/onlinechat/index.php>

Утас: 1900-1212

Холбоо барих статистикч:

Утас: 51-323152 /Ю.БАТЗОРИГТ/

Цахим хаяг: Batzorigt@nso.mn

Хаяг: Засгийн газрын III байр,
Бага тойруу – 44,
Улаанбаатар – 11,
Монгол Улс

Вэб хаяг: www.nso.mn, www.1212.mn

АГУУЛГА

НЭГ. ОРШИЛ.....	3
ХОЁР. МАТЕРИАЛЫН УРСГАЛЫН ДАНСНЫ 2005-2018 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛЭЭРХ ТАНИЛЦУУЛГА	4
2.1. Дотоодод ашигласан олборлолт	4
2.2. Импорт, экспорт, биет хэмжээгээр	5
2.3. Худалдааны тэнцэл, биет хэмжээгээр.....	6
2.4. Материалын шууд орц	7
2.5. Материалын дотоодын хэрэглээ.....	7
2.6. Материал багтаамж, нөөцийн бүтээмж.....	8
2.7. Нэг хүнд ногдох материалын дотоодын хэрэглээ	10
ГУРАВ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ	11
ХАВСРАЛТ	0

НЭГ. ОРШИЛ

НҮБ-ын Статистикийн Комиссын 43-р чуулганаар "Байгаль орчин, эдийн засгийн дансны систем-Ерөнхий хүрээ 2012" олон улсын статистикийн стандарт арга зүйн баримт бичгийг баталж, гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон.

ҮСХ нь 2014 оноос БОЭЗДС-ийг нэвтрүүлж, тус хүрээний биет урсгалын дансны эхний данс болох "Материалын урсгалын данс"-ыг 2005-2013 оны гүйцэтгэлээр анх удаа туршилтаар байгуулсан. Энэхүү туршилт тооцоонд үндэслэн 2015 онд "Материалын урсгалын дансыг байгуулах аргачлал" – ыг боловсруулж, ҮСХ-ны даргын 2015 оны А/77 тоот тушаалаар баталж мөрдөж байсан.

Манай улсад олборлодог металлуудыг хүдэрт шилжүүлэх үндэсний хөрвүүлэх итгэлцүүрийг 2017 онд "Материалын урсгалын данс, 2015-2016" судалгаагаар тогтоож, дээрх аргачлалыг ҮСХ-ны даргын 2018 оны А/64 тоот тушаалаар шинэчлэн баталж, шинэчлэгдсэн аргачлалаар уг дансыг 2005 – 2018 оны гүйцэтгэлээр байгууллаа.

Материалын урсгалын данс нь хуучны материалын болон эрчмийн балансын ойлголт дээр үндэслэгдсэн данс юм. Материалын урсгалын дансыг тогтмол давтамжтайгаар байгуулснаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлнэ.

ХОЁР. МАТЕРИАЛЫН УРСГАЛЫН ДАНСНЫ 2005-2018 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛЭЭРХ ТАНИЛЦУУЛГА

2.1. Дотоодод ашигласан олборлолт

Монгол Улс 2018 онд нийт 238.0 сая тонн материал байгалиас олборлож, эдийн засгийн үйл ажиллагаанд ашигласан байна. Энэ нь 2005 оноос 118.8 сая тонн (99.7%), 2017 оноос 15.7 сая тонн (7.1%) – оор өсжээ.

Хүснэгт 1. Дотоодод ашигласан олборлолт, материалын ангиллаар, мян.тонн


	2005	2010	2015	2017	2018	2018/2005		2018/2017	
						зөрүү	хувь	зөрүү	хувь
Нийт	119 214.5	104 848.1	192 273.2	236 693.4	238 044.8	118 830.2	199.7	15 671.0	107.1
Биомасс	34 555.7	37 017.7	62 097.8	73 140.7	73 827.1	39 271.4	2.1*	4 679.3	106.8
Металлын хүдэр	73 417.0	40 521.3	97 696.2	110 930.1	110 761.1	37 344.1	150.9	- 565.1	99.5
Металл бус эрдэс бүтээгдэхүүн	2 953.2	1 705.6	6 894.2	4 272.6	2 401.1	- 552.1	81.3	46.8	101.1
Эрчим хүчний материал	8 288.7	25 603.6	25 584.9	48 349.9	51 055.5	42 766.8	6.2*	11 510.0	131.2

*- дахин их

Дотоодод ашигласан олборлолтын 2005-2018 оны үр дүнгээс харахад биомасс болон металлын хүдрийн олборлолт дотоодын олборлолтод хамгийн өндөр хувийн жинг эзэлж байна. Энэ нь манай улсын малын тоо толгой, тэдгээрийн байгалиас хэрэглэж байгаа өвс тэжээлийн хэмжээ болон уул уурхай салбарын хөгжилтэй холбоотой.

Мөн эрчим хүчний материалын дотоод олборлолтын хэмжээ 2018 онд 2005 оноос 42.8 сая тонн (6.2 дахин), 2017 оноос 11.5 сая тонн (31.2 хувь) – оор өссөн нь нүүрсний олборлолт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Зураг 1. Дотоодод ашигласан олборлолтын бүтэц, материалын ангиллаар, дүнд эзлэх хувиар



2.2. Импорт, экспорт, биет хэмжээгээр

Манай улс 2018 онд 3.9 сая тонн материал импортолсон нь 2005 оноос 2.2 сая тонн (2.4 дахин), 2017 оноос 511.8 мян.тонн (15.2%) – оор нэмэгдсэн байна.


Хүснэгт 2. Импорт, материалын ангиллаар, мян.тонн

	2005	2010	2015	2017	2018	2018/2005		2018/2017	
						зөрүү	хувь	зөрүү	хувь
Нийт	1 650.7	3 238.5	4 083.6	3 368.9	3 880.7	2 230.1	2.4*	511.8	115.2
Биомасс	430.7	626.6	587.0	587.9	512.5	81.7	119.0	- 75.4	87.2
Металлын хүдэр	181.0	486.9	575.7	605.0	867.7	686.6	4.8*	262.7	143.4
Металл бус эрдэс бүтээгдэхүүн	335.2	1 018.3	1 433.2	455.3	509.2	174.0	151.9	53.9	111.8
Эрчим хүчний материал	599.7	898.4	1 270.8	1 528.8	1 765.4	1 165.7	2.9*	236.5	115.5
Бусад	104.0	208.4	216.9	192.0	226.0	122.0	2.2*	34.0	117.7

*- дахин их

Материалын төрлөөр авч үзвэл, 2018 онд 2005 оноос бүх материалын импортын хэмжээ нэмэгдэж, 2017 оноос металлын хүдэр, эрчим хүчний материал, бусад бүтээгдэхүү болон металл бус эрдэс бүтээгдэхүүний импорт нэмэгдсэн хэдий ч биомассын импорт 75.4 мян.тонн (12.8%) – оор буурчээ.

Зураг 2. Импортын бүтэц, материалын ангиллаар, дүнд эзлэх хувиар



Эрчим хүчний материалын импорт хамгийн өндөр хувийг эзэлсэн хэвээр байна (Зураг 2).

Манай улс 2018 онд 46.9 сая тонн материал экспортолсон нь 2005 оноос 43.5 сая тонн (13.5 дахин), 2017 оноос 4.1 сая тонн (9.5%) – оор нэмэгджээ. Экспортын хэмжээ 2005 оноос 43.5 сая тонн (13.5 дахин) – оор нэмэгдэхэд металлын хүдрийн

экспорт 8.2 сая тонн (10.8 дахин), эрчим хүчний материалын экспорт 34.9 сая тонн (16.5 дахин) – оор нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.


Хүснэгт 3. Экспорт, материалын ангиллаар, мян.тонн

	2005	2010	2015	2017	2018	2018/2005		2018/2017	
						зөрүү	хувь	зөрүү	хувь
Нийт	3 475.7	21 720.6	22 705.8	42 872.9	46 947.3	43 471.5	13.5*	4 074.4	109.5
Биомасс	42.4	83.3	123.7	218.9	174.6	132.2	4.1*	- 44.3	79.8
Металлын хүдэр	838.1	4 287.7	6 711.5	7 897.6	9 069.5	8 231.4	10.8*	1 171.9	114.8
Металл бус эрдэс бүтээгдэхүүн	330.1	410.1	290.6	319.3	557.5	227.4	168.9	238.2	174.6
Эрчим хүчний материал	2 254.2	16 938.8	15 579.1	34 435.4	37 144.0	34 889.8	16.5*	2 708.6	107.9
Бусад	11.0	0.7	0.9	1.7	1.7	- 9.3	15.5	0.0	100.0

*- дахин их

Эрчим хүчний материалын экспорт 2017 онд нийт экспортод хамгийн өндөр хувь буюу 80.3 хувийг, 2018 онд 79.1 хувийг эзэлж байна.

Зураг 3. Экспортын бүтэц, материалын ангиллаар, дүнд эзлэх хувиар



2.3. Худалдааны тэнцэл, биет хэмжээгээр

Мөнгөн дүнгээр илэрхийлсэн, гадаад худалдааны тэнцлийг экспортоос импортыг хасаж тооцдог бол биет хэмжээгээрх гадаад худалдааны тэнцлийн хувьд эсрэгээр нь импортоос экспортыг хасна.

Худалдааны тэнцэл 2005-2018 онд алдагдалтай гарсан байна. Энэ нь манай улс импортоосоо илүү их материалыг экспортолж байна гэсэн үг юм.

Импортын хэмжээ 2018 онд 2005 оноос 2.4 дахин өссөн хэдий ч экспортын хэмжээ 13.5 дахин өссөн нь худалдааны тэнцлийн алдагдал 23.6 дахин нэмэгдэхэд хүргэсэн байна.

Хүснэгт 4. Худалдааны тэнцэл, мян.тонн

	2005	2010	2015	2017	2018	2018/2005		2018/2017	
						зөрүү	хувь	зөрүү	хувь
Худалдааны тэнцэл	-1 825.1	-18 482.1	-18 622.2	-39 503.9	-43 066.6	-41 241.5	23.6*	-3 562.7	109.0
Импорт	1 650.7	3 238.5	4 083.6	3 368.9	3 880.7	2 230.1	2.4*	511.8	115.2
Экспорт (-)	3 475.7	21 720.6	22 705.8	42 872.9	46 947.3	43 471.5	13.5*	4 074.4	109.5

*- дахин их

2.4. Материалын шууд орц

Материалын шууд орцыг дотоодод ашигласан материалын олборлолт болон импортолсон материалын нийлбэрээр тооцно.

Материалын орцын хэмжээ 2018 онд 241.9 сая тонн болж, 2005 оноос 121.1 сая тонн (2.0 дахин), 2017 оноос 1.8 сая тонн (0.8%) – оор нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. Материалын шууд орц, мян.тонн

	2005	2010	2015	2017	2018	2018/2005		2018/2017	
						зөрүү	хувь	зөрүү	хувь
Материалын шууд орц	120 865.2	108 086.6	196 356.8	240 062.3	241 925.5	121 055.4	2.0*	1 863.2	100.8
Дотоодод ашигласан олборлолт	119 214.5	104 848.1	192 273.2	236 693.4	238 044.8	118 825.3	199.7	1 351.4	100.6
Импорт	1 650.7	3 238.5	4 083.6	3 368.9	3 880.7	2 230.1	2.4*	511.8	115.2

*- дахин их

2.5. Материалын дотоодын хэрэглээ

Эдийн засаг дахь материалын дотоодын хэрэглээг материалын шууд орцоос экспортыг хасаж тооцно.

Манай улсын эдийн засаг дахь материалын хэрэглээ 2018 онд 195.0 сая тонн болж, 2005 оноос 77.6 сая тонн (66.1%) – оор өсөж, 2017 оноос 2.2 сая тонн (1.1%) – оор буурсан байна.

Хүснэгт 6. Материалын дотоодын хэрэглээ, мян.тонн

	2005	2010	2015	2017	2018	2018/2005		2018/2017	
						зөрүү	хувь	зөрүү	хувь
Материалын дотоодын хэрэглээ	117 389.4	86 366.0	173 651.0	197 189.4	194 978.2	77 588.8	166.1	-2 211.3	98.9
Материалын шууд орц	120 865.2	108 086.6	196 356.8	240 062.3	241 925.5	121 060.3	2.0*	1 863.2	100.8
Экспорт (-)	3 475.7	21 720.6	22 705.8	42 872.9	46 947.3	43 471.5	13.5*	4 074.4	109.5

*- дахин их

Материалын шууд орц буюу дотоодод ашигласан олборлолт болон импортын хэмжээ нэмэгдсэн хэдий ч экспортын хэмжээ эдгээрээс илүүгээр нэмэгдсэнээр материалын дотоодын хэрэглээ буурсан байна.

Материалын дотоодын хэрэглээнд металлын хүдэр болон биомассын эзлэх хувийн жин өндөр байна.

2.6. Материал багтаамж, нөөцийн бүтээмж

Материал багтаамж: Тухайн улсын эдийн засгийн материалын үр ашгийг тодорхойлох үзүүлэлт бөгөөд материалын дотоодын хэрэглээг ДНБ-д харьцуулж тодорхойлно.

Нөөцийн бүтээмж: Энэ үзүүлэлтийг материалын багтаамжийн урвуу буюу ДНБ-ийг материалын дотоодын хэрэглээнд харьцуулж тодорхойлно. Нөөцийн бүтээмж нь зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангахын тулд эдийн засаг дахь бараа, үйлчилгээний үйлдвэрлэлд нөөцийг хэрхэн үр ашигтай ашигласныг харуулна. Хэрвээ ДНБ нь материалын дотоодын хэрэглээнээс илүү өсвөл нөөцийн бүтээмж өссөнийг харуулна.

Хүснэгт 7. Материал багтаамж, нөөцийн бүтээмж


	2005	2010	2015	2017	2018*	2018/2005		2018/2017	
						зөрүү	хувь	зөрүү	хувь
Материал багтаамж, кг/сая төг	38 597	8 852	7 501	7 069	6 062	-32 535	16	-1 007	85.8
Нөөцийн бүтээмж, төг/кг	26	113	133	141	165	139	6.4**	24	116.6

*- урьдчилсан гүйцэтгэл

**-дахин их

Манай улс тухайн оны үнээр 2005 онд 38.6 тонн материалаар 1 сая төгрөгийн ДНБ-ийг үйлдвэрлэдэг байсан бол 2017 онд 7.1 тонн, 2018 онд 6.1 тонн материалаар 1 сая төгрөгийн ДНБ үйлдвэрлэсэн байна.


Зураг 4. Материал багтаамж, кг/сая төгрөг



**-урьдчилсан гүйцэтгэл*

Харин нөөцийн бүтээмж талаас нь авч үзвэл, манай улс 2005 онд 1 кг материалаар 26 төгрөгийн нэмэгдэл өртөг үйлдвэрлэж байсан бол 2017 онд 141 төгрөг, 2018 онд 165 төгрөгийн нэмэгдэл өртөг үйлдвэрлэсэн байна.

Зураг 5. Нөөцийн бүтээмж, төг/кг




**-урьдчилсан гүйцэтгэл*

Материал багтаамж болон нөөцийн бүтээмжийн 2005 – 2018 оны мэдээллээс харахад 2012 онд материал/нөөцийг хамгийн үр ашигтай зарцуулсныг харж болохоор байна.

2.7. Нэг хүнд ногдох материалын дотоодын хэрэглээ

Нэг хүнд ногдох материалын дотоодын хэрэглээ нь “Тогтвортой хөгжлийн зорилго – 2030” хөтөлбөрийн нэг чухал үзүүлэлт юм.

Зураг 6. Нэг хүнд ногдох материалын дотоодын хэрэглээ, тонн



Манай улсын нэг хүнд ногдох материалын дотоодын хэрэглээ 2018 онд 60.8 тонн болж, 2005 оноос 14.5 тонноор нэмэгдэж, 2017 оноос 1.8 тонноор буурчээ.

ГУРАВ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Материалын урсгалын дансыг тогтмол байгуулж, материалын үр ашиг, харьцааг тодорхойлох нь бодлого боловсруулах, шийдвэр гаргахад хэрэгцээтэй мэдээлэл болно.

Байгалийн нөөцийн ашиглалт, түүний бүтээмж, нөөцийн хараат байдал зэргийг хэмжсэн үзүүлэлтийг дан ганц байгалийн нөөцийн менежментийг үр ашигтай явуулахад бус цаашилбал улс орнуудын хооронд харьцуулалт хийхэд ашигладаг.

Цаашид олон улсад зэрэгцүүлэх материалын урсгалын үзүүлэлтүүдийг гүнзгийрүүлэн судлах, тооцох болон эдийн засаг, нийгмийн бусад үзүүлэлтүүдтэй холбож эконометриксийн харилцан хамаарал, нөлөөллийн дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.

ХАВСРАЛТ

Хүснэгт 1. Дотоодод ашигласан олборлолт, материалын ангиллаар, мян.тонн, 2005–2018 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийт	119 214.5	121 127.9	116 866.8	114 589.9	107 608.2	104 848.1	116 471.7	121 115.8	152 862.4	174 252.6	192 273.2	221 022.3	236 693.4	238 044.8
Биомасс	34 555.7	38 445.0	43 138.0	45 221.6	46 400.2	37 017.7	40 862.2	45 488.6	50 139.5	57 878.7	62 097.8	68 461.4	73 140.7	73 827.1
Металлын хүдэр	73 417.0	71 685.5	61 314.0	56 212.8	46 194.1	40 521.3	41 120.7	44 133.8	61 678.2	81 492.9	97 696.2	111 495.3	110 930.1	110 761.1
Металл бус эрдэс бүтээгдэхүүн	2 953.2	3 050.2	3 536.1	3 170.3	1 543.7	1 705.6	3 131.3	2 337.0	11 041.3	8 741.3	6 894.2	4 225.8	4 272.6	2 401.1
Эрчим хүчний материал	8 288.7	7 947.2	8 878.6	9 985.2	13 470.2	25 603.6	31 357.5	29 156.4	30 003.5	26 139.8	25 584.9	36 839.9	48 349.9	51 055.5

Хүснэгт 2. Импорт, материалын ангилалаар, мян.тонн, 2005-2018 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийт	1 650.7	1 853.2	2 535.9	3 156.0	2 631.2	3 238.5	4 584.2	5 118.4	5 284.0	4 955.9	4 083.6	3 137.8	3 368.9	3 880.7
Биомасс	430.7	447.8	540.2	723.4	566.9	626.6	567.0	613.7	599.6	623.7	587.0	731.7	587.9	512.5
Металлын хүдэр	181.0	208.4	347.9	528.5	334.9	486.9	1 036.3	977.5	824.4	757.4	575.7	413.4	605.0	867.7
Металл бус эрдэс бүтээгдэхүүн	335.2	403.8	661.3	828.0	747.6	1 018.3	1 604.7	2 240.3	2 174.1	2 086.2	1 433.2	627.4	455.3	509.2
Эрчим хүчний материал	599.7	681.3	851.5	912.1	811.9	898.4	1 049.8	939.1	1 413.9	1 231.6	1 270.8	1 186.1	1 528.8	1 765.4
Бусад	104.0	112.0	135.0	164.0	169.8	208.4	326.3	347.8	272.0	257.0	216.9	179.1	192.0	226.0

Хүснэгт 3. Экспорт, материалын ангилалаар, мян.тонн, 2005-2018 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийт	3 475.7	3 890.7	4 833.7	6 500.1	10 197.2	21 720.6	28 754.7	29 172.4	27 045.4	28 753.8	22 705.8	35 305.1	42 872.9	46 947.3
Биомасс	42.4	64.1	68.7	64.1	75.5	83.3	88.8	83.6	99.2	122.8	123.7	197.0	218.9	174.6
Металлын хүдэр	838.1	1 046.2	1 010.7	1 752.2	2 360.1	4 287.7	6 527.4	7 143.9	7 523.1	7 871.6	6 711.5	7 941.5	7 897.6	9 069.5
Металл бус эрдэс бүтээгдэхүүн	330.1	356.1	363.0	354.1	314.4	410.1	407.3	429.1	339.1	314.2	290.6	248.9	319.3	557.5
Эрчим хүчний материал	2 254.2	2 415.5	3 384.9	4 324.2	7 441.2	16 938.8	21 730.5	21 515.1	19 082.6	20 444.0	15 579.1	26 915.9	34 435.4	37 144.0
Бусад	11.0	8.8	6.4	5.4	6.1	0.7	0.8	0.7	1.4	1.2	0.9	1.9	1.7	1.7

Хүснэгт 4. Худалдааны тэнцэл, мян.тонн, 2005-2018 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Худалдааны тэнцэл	-1 825.1	-2 037.4	-2 297.8	-3 344.1	-7 566.0	-18 482.1	-24 170.6	-24 054.0	-21 761.4	-23 797.9	-18 622.2	-32 167.3	-39 503.9	-43 066.6
Импорт	1 650.7	1 853.2	2 535.9	3 156.0	2 631.2	3 238.5	4 584.2	5 118.4	5 284.0	4 955.9	4 083.6	3 137.8	3 368.9	3 880.7
Экспорт (-)	3 475.7	3 890.7	4 833.7	6 500.1	10 197.2	21 720.6	28 754.7	29 172.4	27 045.4	28 753.8	22 705.8	35 305.1	42 872.9	46 947.3

Хүснэгт 5. Материалын шууд орц, мян.тонн, 2005-2018 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Материалын шууд орц	120 865.2	122 981.1	119 402.7	117 745.9	110 239.4	108 086.6	121 055.9	126 234.2	158 146.4	179 208.5	196 356.8	224 160.1	240 062.3	241 925.5
Дотоодод ашигласан олборлолт	119 214.5	121 127.9	116 866.8	114 589.9	107 608.2	104 848.1	116 471.7	121 115.8	152 862.4	174 252.6	192 273.2	221 022.3	236 693.4	238 044.8
Импорт	1 650.7	1 853.2	2 535.9	3 156.0	2 631.2	3 238.5	4 584.2	5 118.4	5 284.0	4 955.9	4 083.6	3 137.8	3 368.9	3 880.7

Хүснэгт 6. Материалын дотоодын хэрэглээ, мян.тонн, 2005-2018 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Материалын дотоодын хэрэглээ	117 389.4	119 090.5	114 569.0	111 245.8	100 042.2	86 366.0	92 301.1	97 061.8	131 101.1	150 454.7	173 651.0	188 855.0	197 189.4	194 978.2
Материалын шууд орц	120 865.2	122 981.1	119 402.7	117 745.9	110 239.4	108 086.6	121 055.9	126 234.2	158 146.4	179 208.5	196 356.8	224 160.1	240 062.3	241 925.5
Экспорт (-)	3 475.7	3 890.7	4 833.7	6 500.1	10 197.2	21 720.6	28 754.7	29 172.4	27 045.4	28 753.8	22 705.8	35 305.1	42 872.9	46 947.3

Хүснэгт 7. Материал багтаамж болон нөөцийн бүтээмж, 2005-2018 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018*
Материал багтаамж, кг/сая төг	38 597	29 569	23 114	16 970	15 179	8 852	7 006	5 816	6 837	6 769	7 501	7 888	7 069	6 062
Нөөцийн бүтээмж, төг/кг	26	34	43	59	66	113	143	172	146	148	133	127	141	165

*- урьдчилсан гүйцэтгэл

Хүснэгт 8. Нэг хүнд ногдох материалын дотоодын хэрэглээ, тонн, 2005-2018 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нэг хүнд ногдох материалын дотоодын хэрэглээ	46.3	46.4	44.0	42.1	37.2	31.5	33.1	34.2	45.2	50.8	57.4	61.1	62.6	60.8